

МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ТЕХНОЛОГИ АШИГЛАН ЦАХИМ СУРГАЛТ ЯВУУЛАХАД БАГШ НАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

(Дорнод аймгийн ЕБСургуулиудийн жишээн дээр)

Т.Гантулга, Б.Буянцэцэг, Г.Баярцэцэг

tulgaa99@gmail.com

Дорнод Их Сургууль

Хураангуй

Дэлхий даяар анх удаа зайны сургалтад шилжсэн энэ үед танхимд сурган хүмүүжүүлэх ухаан, заах арга зүйг судлан эзэмшсэн багш нарт мэдээлэл харилцааны технологийг өндөр түвшинд эзэмшин ажиллах шаардлага зүй ёсоор тавигдсан. Энэ нь COVID-19 буюу шинэ төрлийн вирусийн халдвар цар тахлын үед хүн бүрд тулгамдаж буй асуудал болоод байна. Уг тахлын улмаас дэлхий нийтээр хөл хорио тогтоож танхимын сургалтыг түр хугацаагаар хязгаарласан нь суралцагчдад телевиз болон мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан цахимаар бие даан суралцах чадварт суралцуулж байна. Тиймээс COVID-19 нь буюу шинэ төрлийн вирусийн халдвар цар тахал нь Монгол улс болон дэлхий нийтэд цахим сургалтыг хөгжүүлэх зайлшгүй чухал шаардлага байгааг ойлгуулсан, цахим сургалт эрчимтэй хөгжих боломж гарсан билээ. Боловсролын салбарт хамгийн шинэ өөрчлөлтийг авчирч байгаа МХТ-ийг ашигласан цахим хичээлийг сургалтад хэрхэн ашиглаж байгаа талаар Дорнод аймгийн ЕБСургуулиудийн жишээн дээр судалгаа хийж үзлээ.

Түлхүүр үг: Мэдээлэл технологи, Теле хичээл, цахим сургалт, хөтөч багш

Оршил:

Дэлхий дахинд COVID-19 буюу шинэ төрлийн коронавирусын халдвар цар тахлын улмаас МУ-ын ЗГ, улсын Онцгой комиссоос шийдвэр гаргасантай холбогдуулан 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн өргөн нэвтрүүлгийн 18 телевизийн сувгаар өдөрт 2-4 хичээлийг тус бүр 10-20 минутын хугацаатай заагдахаар агуулга, хуваарь батлагдан гарсан нь үүсээд буй нөхцөл байдал, цахим сургалтын мөн чанарыг таниулсан өгсөн билээ. Энэ хугацаанд БСШУСЯ, БМДИ, Монголын телевизүүдийн холбооны хамтарсан баг нийт 2184 цагийн хичээлийг бэлтгэн заагаад байна.

Дорнод аймгийн ЕБСургуулиас танхимын сургалтыг интернэт, олон нийтийн цахим сүлжээ буюу фейсбүүк болон бусад сургалтын платформ, программуудыг ашиглаж зайн хэлбэрээр зохион байгуулж, 1-5 дугаар ангийн 26 бүлгийн 934 сурагч, 6-9 дүгээр ангийн 16 бүлгийн 521 сурагч, ахлан ангийн 7 бүлгийн 180 сурагч, нийт 1635 сурагч, 70 багш суралцагчидтайгаа зайнаас холбогдон суралцаж байгаа талаар судалгаа хийсэн.

Багш, суралцагчдын хувьд анх удаа цахимаар суралцаж байгаа бөгөөд гэртээ тогтмол интернет байхгүй, байгууллагын интернетийн хурд удаан, багшийн ашиглаж буй компьютер, тоног төхөөрөмж шаардлага хангахгүй, МХТ-той ажиллах мэдлэг дутмаг, янз бүрийн программ, портал сайтууд болон үнэгүй ашиглах боломтой аппликейшныг хэрэглэж чадахгүй байх, бэлтгэсэн цахим хичээлийг хүлээж авч байгаа суралцагчдын ухаалаг утас, тоног төхөөрөмж, интернет орчин зэрэг нь шаардлага хангахгүй, дутагдалтай байх гэх мэт тулгамдаж буй асуудал нилээдгүй байсан. Тиймээс зайны сургалт зохион байгуулахад багш нарт тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, тэдгээрийг шийдвэрлэхэд дэмжлэг болох зорилгоор энэ судалгааны ажил хийлээ.

Зорилго:

ЕБСургуулийн багш нарын мэдээлэл харилцааны технологи ашиглах ур чадварыг үнэлэх, Багш нарт зайнаас сургалт явуулах, багш, сурагч, эцэг эхтэй холбогдох, цахим хичээл бэлтгэх, онлайн хичээлийн тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, түүнийг шийдвэрлэх

Зорилтууд:

- Мэдээлэл харилцааны технологийн талаархи асуулга судалгаа боловсруулан багш нараас авах
- ЕБС-ийн багш нарийн МХТ ашиглан зайнаас сургалт явуулахад тулгамдаж буй асуудлыг илрүүлэх
- Судалгааны үр дүнг дүгнэж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, санал, зөвлөмж гаргах

Судалгааны арга, арга зүй:

Судалгаанд Дорнод аймгийн төвийн ЕБС-ийн 70 багш хамрагдсан.

Теле хичээл зайны сургалтын үед багш нар хэрхэн ажиллаж буй, цахим тоон мэдээ, тайлан мэдээнээс судлахаар ажиглалтын аргыг; ЕБС-ийн багш нар зайны сургалтыг зохион байгуулахад тулгамдаж буй асуудлыг илрүүлэх зорилгоор асуулгын аргыг GOOGLE FORM ашиглаж сургуулийн багш нарын бүлгэмээр дамжуулан авсан. Судалгааны анализыг Excel, SPSS программ ашиглан боловсруулав.

Оршил:

Монгол улсын засгийн газар, улсын Онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу теле хичээлийн агуулга, хуваарь батлагдан Багш, суралцагчдын хувьд анх удаа цахимаар суралцаж байгаа бөгөөд сургалтын үйл ажиллагаа хэвийн нөхцөл танхимын сургалтад 7 хоногт нийт суралцагчдийн 98 хувь 1630 сурагч, 70 багш тогтмол хамрагддаг. Харин хөл хорио тогтоон зайнаас сургалт явуулах хугацаанд нийт сурагчдын 72 хувь 1177 сурагч, 38 багш тогтмол хамрагдаж байна. Үүнд багшид тогтмол интернет байхгүй, байгууллагын интернетийн хурд удаан, багшийн ашиглаж буй компьютер, тоног төхөөрөмж шаардлага хангахгүй, МХТ-ийн мэдлэг дутмаг, янз бүрийн программ, үнэгүй ашиглах боломжтой аппликейшныг хэрэглэж чадахгүй байх, суралцагчдын ухаалаг утас, тоног төхөөрөмж, интернет орчин зэрэг нь шаардлага хангахгүй, дутагдалтай байх гэх мэт асуудлууд тулгамдаж байж болох юм. Иймээс эдгээр асуудлыг тодорхойлох зорилгоор ажиглалт судалгаа явуулж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн, сургалтын үйл ажиллагаанд багш, суралцагчдыг бүрэн хамруулах шаардлага үүсээд байна.

Үндсэн хэсэг

Судлагдсан байдлын тойм

1. Зайны сургалтын үндэсний хөтөлбөр 2002-2010

“Шинэ зууны боловсролын нэг гол шинж бол нээлттэй сургалт, зайны сургалт. Боловсролын хэрэгцээг орон зай, цаг хугацаанаас төдийлөн шалтгаалахгүйгээр уян хатан, олон хувилбартай, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар хангах тогтолцоо бий болгох нь чухал бөгөөд Монгол улсын боловсролын салбарт зайны сургалтыг хэрэгжүүлэх хөтөлбөр хэрэгжээд 20-иод жил болсон байна.

2. Боловсролын салбарт мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар баримтлах бодлого (2012-2016)

Боловсролын салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийг үр өгөөжтэй нэвтрүүлэх замаар боловсролын хүртээмж, чанарыг ахиулах, тэгш байдлыг хангах, сургалтын цахим орчин бүрдүүлэх, боловсролын үйлчилгээг тогтвортой хөгжүүлэх зорилготойгоор багшийн МХХТ-ийн мэдлэг, ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, түүнийг үнэлэх үндэсний стандарт боловсруулж хэрэгжүүлэх гэж тусгасан боловч “Цахим сургалтын удирдлагын мэдээллийн систем”-ээс багш сурагчийн сурлагын амжилтын тайлан, цаасгүй цахим систем, сургуулийн үйл ажиллагаа, тайлан, судалгаа, нэгэн доор гарч ирэх систем хараахан бүрдээгүй байна

3. Судлаач Н.Бат-Эрдэнэ “Цахим боловсролын чиг хандлага” (2015) ЭШӨ-д

Цахим боловсролын дэлхий нийтийн чиг хандлагыг судлан үзэж “Цахим боловсролын хэрэглээ нь байгууллагуудад өдрөөс өдөрт

нэмэгдэн, Дэлхий нийтийн чиг хандлагаас харахад э-сургалт нь жил ирэх тусам өсөх хандлагатай байна. Иймд амжилттай хэрэгжиж байгаа улс орнуудтай хамтран сургалт явуулах, туршлага солилцох зэргээр мэдээллээ мэдлэг болгох энэ салбарт хөгжил авчирна” гэж дүгнэсэн байна.

4. ШУТИС-ийн багш Б.Батшагай, Т.Уранчимэг нар “Зайн Сургалтын Хөтөч Багшийн Цахим Хэрэглэгдэхүүнүүдийн Судалгаа”-нд

“Зайн сургалт хөтлөн явуулж буй багшийн заах арга зүйн онцлог, сургалтад ашиглах шинэ хэрэглэгдэхүүнийг судалсан байна. Тэд судалгаандаа тэнхимийн багш болон хөтөч багш гэсэн нэршлийг хэрэглэж тэдгээрийн хэрэглэгдэхүүн, заар арга зүйн онцлогийг тодруулжээ.

5. Монгол Улсын Их Сургуулийн багш З. Цолмон, С. Отгонцэцэг, Ч. Лодойравсал нар “МУИС-ийн Оюутнуудын Онлайн Сургалтад Оролцох Бэлэн Байдлын Үнэлгээ” судалгаанд

“Онлайн сургалт нь оюутнуудын сурах арга барилыг сайжруулж, оюутны хувийн зохион байгуулалт, бие даан ажиллах, цаг ашиглах, зохицуулах, өөрөө өөртөө шаардлага тавих чадамжийг эрс нэмэгдүүлдэг харилцааны буюу онлайнаар багшийн удирдлаган доор чадамжид суралцуулдаг давуу талтай гэж үзжээ.

6. МУБИС-ийн багш Б.Норжинбуу “Нийгмийн Сүлжээ Хэрэглэгчдийн Өнөөгийн Байдал” (2015) судалгааны бүтээлд

“Манай улсын нийгмийн сүлжээ хэрэглэгчид залуу, өсвөр насныхан байна. Нийгмийн сүлжээг зөв ашиглаж чадвал маш том боломж, зах зээл. Англи, Америк, Энэтхэгт Facebook, Twitter зэрэг сайтыг боловсролд тэр дундаа их дээд сургуулийн сургалтад ашиглаж эхэлсэн байна. Манай улс ч боловсролын салбарт зайны болон модуль сургалтууд зохион байгуулахад Facebook сайтыг ашиглах боломж байсаар байна” гэж дүгнэсэн байна.

7. ШУТИС-ийн багш Б.Тунгалаг, Б.Цэцэгээ нар “Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн хандлага, тулгамдаж буй асуудлууд” ЭШӨ-д

“МТХХ-ны хөгжил гарт баригдаж, нүдэнд харагдаж, хувь хүмүүсийн хэрэглээ болоод “Ухаалаг утасны нийгэм” рүү хийх шилжилт явагдаж байна гэж дүгнэжээ.


2. Судалгаанд хамрагдагсдын өнөөгийн байдлын талаарх судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан багш нарыг насны ангиллаар авч үзвэл дийлэнх буюу 42.4% 31-40 настай, 23.7% нь 26-30 настай багш нар байна. Ажилласан жилээр авч үзвэл 27.1 % нь 11-15 жил, 22 % нь 3-5 жил ажилласан багш нар байна.

Судалгаанд хамрагдсан багш нарыг судлагдахууны хувьд авч үзвэл бага боловсролын багш 25.4 % байгалийн ухааны багш нар 18.6 % эзэлж байна.

Зураг 1.

Та ямар судлагдахууны багш вэ?



Судалгаанд оролцсон багш нарын 80% нь өмнө нь онлайнаар зайнаас сургалт явуулж байгаагүй, тийм болон заримдаа гэсэн хариултыг Мэдээлэл зүй-математикийн багш нар өгсөн.

Багш нарын хувьд сурагчдад зайны сургалтыг 22.3% нь Power point хэлбэрээр, 18.7 % нь видео хэлбэрээр, 16.6% нь зурган файл хэлбэрээр бэлтгэж байна. Багш нарын 19.4 % нь теле хичээлийн агуулгаар л хичээлийг зохион байгуулж байна.


Зүраг 2.



Багш нарын 51 % нь нэг удаагийн цахим хичээл бэлтгэхэд 3 ба түүнээс дээш цагийг 27% нь 2-4 цаг зарцуулж байна. Теле хичээлийн агуулга, арга зүйг судлах, тухайн хичээлд холбогдох нэмэлт даалгавар, давтлага хичээл, орхигдсон агуулгыг нөхөх зэрэгт 2 ба түүнээс дээш цагийг 77.9 % зарцуулж байна. Үүнийг багшийн ачаалалтай холбон үзвэл бага боловсролын багш хуваарийн дагуу өдөрт 2-3 хичээлийн агуулгад 4-6 цаг дунд, ахлах ангийн багш дунджаар өдөр 3-4 ангийн хичээл гарч байна. Энэ нь тухайн багш өдөрт теле хичээлийн агуулга бүрээр анги бүрт нэмэлт даалгавар, давтлага хичээл, орхигдсон агуулгыг нөхөх хичээл бэлтгэхэд 6-12 цаг зарцуулах юм. Тиймээс багш нарын хувьд тухайн хичээл тус бүрээр өдөр бүр нэмэлт агуулга хичээл бэлтгэх нь цаг хугацаа их зарцуулах болж байна.

Зураг 3.

Та 1 удаагийн цахим хичээлийг боловсруулахад хэр их цаг зарцуулж байна вэ?



Зайнаас сургалт явуулахад багш нарын 40.6% нь өөрсдийнхөө мэдээлэл харилцааны технологи ашиглах чадварыг мүү гэж дүгнэсэн байна.

Зураг 4.

Цахимаар буюу зайны сургалт зохион байгуулахад ямар асуудал тулгамдаж байна вэ?



Дүгнэлт

1. Багш нарын дийлэнх 70% өмнө нь зайны сургалт зохион байгуулах, онлайнаар сурагчдыг үнэлж дүгнэх үйл ажиллагаа зохион байгуулж байгаагүй.
2. Багш нар гол төлөв power point-оор бэлтгэсэн хичээл, зураг, видеог зайны сургалтад хэрэглэж байна. Ихэнх багш нар теле хичээлээр зайны сургалтын агуулгыг хязгаарлаж байгаа нь судалгааны дүгнэлтээс харагдлаа.
3. Багш нарын дийлэнх хувь нь нэг удаагийн цахим хичээл бэлтгэхэд 2 ба түүнээс дээш цагийг зарцуулж байгаа нь багш нар цахим хичээл бэлтгэхэд цаг хугацаа зарцуулан суралцаж байгаа нь багш нарын хувьд мэдээлэл харилцааны технологитой ажиллах үр чадвар сул байгааг харуулж байна.
4. Багш нарын тайлан мэдээ бичих, цахим хичээл бэлтгэж буйг ажиглахад ихэвчлэн Word, Excel, PowerPoint программыг байнга, Publisher, VideoEditor, PDF, Google form, Classroom зэрэг программыг заримдаа цөөн тооны багш нар ашигла байна.

Санал

Танхимын сургалтын үйл ажиллагааг олон жил зохион байгуулж үрсэн манай багш нар дэлхий нийтийн цар тахалтай холбоотойгоор хөтөч багш нар болох шаардлага үүсэж байна. Хөтөч багшийн гол үүрэг бол МХТ-ийн мэдлэгтэй, зайнаас суралцаж байгаа суралцагчийн суралцах хүсэл эрмэлзлийг сэдрээх, улам идэвхжүүлэх, нүүр тулахгүйгээр сурах арга барилд сургах, улмаар зайн сургалтын давуу талуудыг мэдрүүлэн сургалтаа амжилттай дуусгахад нь дэмжлэг үзүүлэх явдал юм. Тиймээс дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Жил бүр БМДИ-ээс 1,5,10 дахь жилдээ ажиллаж буй багш нарын үндсэн сургалт, аймгийн БСУГ-аас 2,3,4 дэх жилдээ ажиллаж буй багш нарын үндсэн сургалтыг тогтмол зохион байгуулахдаа зайнаас хичээл удирдах, орчин үеийн нийгмийн сүлжээний програмуудын талаар өргөн мэдлэг ойлголт өгөх агуулга, чадварыг эзэмшүүлэх сургалтыг нэмж багтаах шаардлагатай байна.
2. Цаашид ЕБС-ийн хэмжээнд багш нарын МХТ-той ажиллах, энэ талын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалт үйл ажиллагааг хичээлийн жилийн хугацаанд багш нараа хөгжүүлэх

“Багшийн хөгжил” дэд хөтөлбөрт түлхүү тусган төлөвлөн хэрэгжүүлэх нь нэн тэргүүний асуудал болж байна.

3. Зайны сургалтыг явуулах мэдлэг, ур чадварыг багш мэргэжил эзэмших явцад давхар олгох, орчин үеийн мэдээллийн эрин үеийн техник, программуудтай ажиллах чадварыг багшийн үндсэн чадварын нэг болгож оруулж өгөх шаардлагатай байна.
4. Багш нарыг идэвхжүүлэх, өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих үүднээс МХТ-ийг хэрэглэх ур чадварын түвшингийн уралдаан тэмцээн зохион байгуулах, урамшуулах, багшийг алдаршуулах үйл ажиллагааг хийх хэрэгтэй байна.
5. Аймгийн БСУГ-ын мэргэжилтнүүд сар бүр / зарим нь 14 хоногт 1 удаа / өөрийн хариуцсан судлагдахууны багш нартай заах аргын нэгдлийн ажлыг зохион байгуулж цаг үеийн мэдээ мэдээлэл өгч, хичээлийн судалгааг зохион байгуулахдаа судлагдахуунаараа хамтран багаар ажиллуулан, нэг ээлжит хичээлийн цахим хэрэглэгдэхүүнийг бэлтгэх замаар цахим хичээлийн нөөц сантай болох боломжтой.
6. Дэлхий нийтээр ухаалаг утасны хэрэглээ нийгэм рүү шилжиж буй энэ цаг үе нь өнөөдрийн цар тахлын үетэй зэрэгцэж ухаалаг утсаар суралцах нөхцөл байдал зүй зохистойгоор ашиглах хэрэгцээ шаардлага үүсээд байна. Тиймээс багш, эцэг дэмжих хэрэгтэй.

Ном зүй

1. Багадунд боловсрол. Мэдээлэл зүйн боловсрол, MNS 5420-7:20048 (2005) Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, Улаанбаатар
2. “Багшийн МХТ-ийн чадамжийн хүрээ Юнеско-гийн зөвлөмж” (2011) Юнеско, Мэдээллийн Технологийн Институтын хамтарсан Монгол орчуулга
3. Боловсролын салбарын мэдээллийн систем, (2017) www.esis.edu.mn, БСШУСЯ,
4. Мэдээллийн технологийн талаар баримтлах бодлого, (2010) Ашигт малтмалын газар, Улаанбаатар
5. Мөнхцэцэг Н, Д.Гармаа. (2012) “Цахим сургалтад нээлттэй эхүүдийг ашиглах нь” Хүрээ дээд сургууль, “Нээлттэй эхийн форум” 24-29.
6. Уранчимэг Т, Б.Батшагай, (2009) “Сургалтын шинэ технологи буюу виртуаль лаборатори”, МУИС, МКС, Монгол улсын их дээд сургуулиудын компьютерийн ухааны чиглэлээр дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр, олон улсын туршлага, хандлага - Эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар хот, 32-34.
7. Уянга. С, (2009) Системийн шинжилгээ ба зохиомж, Улаанбаатар принт ХХК, Улаанбаатар
8. Цэдэвсүрэн, Д. нар (2010) Мэдээлэл зүйн боловсролын стандартад Портерийн загвараар шинжилгээ хийсэн судалгааны үр дүн, Лавай дугаар 5, х: 86-90, Улаанбаатар
9. Цэдэвсүрэн, Д. (2014) Мэдээлэл зүйн багш ба мэдээлэл зүйн боловсрол, МХХТ ба боловсрол эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, дугаар 6, х: 1-5, Улаанбаатар
10. Чимгээ. Д, (1998), Менежментийн мэдээллийн систем, Улаанбаатар